



# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3.208.489...



Худалдах үнэ 500 төг

2018.06.06. Лхагва. №112 (4962)

ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ

[www.dardas.mn](http://www.dardas.mn)  
[facebook.com/dardas.mn](https://facebook.com/dardas.mn)  
[twitter.com/MMdardas](https://twitter.com/MMdardas)  
[mongolinmedeesonin@gmail.com](mailto:mongolinmedeesonin@gmail.com)

- "Дэлхийн сонины холбоо"-ны гишүүн
- 1999 оны шилдэг чөлөөт хэвлэл
- 2002 оны шилдэг хэвлэл
- 2013 оны Монгол Улсын шилдэг сонин
- Best of Mongolia-2016 - Оны шилдэг сонин



Улаанбаатар: ӨНӨӨДӨР

Өдөр +15  
Шөнө +8

20 дахь жилдээ

Дугаарыг эрхэлсэн Сэрдамбын БУДРАГЧАА

ЭГЭЛ АМЬДРАЛ



## ХОС ОДОНГИЙН ЭЗЭН



Б.ДАВААХҮҮ  
Davaakhuu0128@gmail.com

Саяхан болж өнгөрсөн Хүүхдийн баярын өдрөөр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга олон хүүхэд төрүүлж, өсгөж буй 43 ээжид Алдарт эхийн нэг, хоёрдугаар зэргийн одон гардуулсан бөгөөд тэдний дунд энэ бүсгүйн нэр багтсанаар Баянхонгор аймгаас нийслэлийг зорьж ирсэн нь энэ аж.

Б.Баяржаргал эдүгээ 32 настай. Насыг нь бодвол төдийлөн олон хүүхэдгүй болов уу гэх сэтгэгдэл төрөх хэдий ч, тэр зургаан сайхан хүүгийн хайртай ээж ажээ. Том хүү Х.Эрдэнэбаярыгаа оюутан ахуй цагтаа буюу 2005 онд төрүүлсэн бол 2012 онд Х.Хос-Эрдэнэ, Х.Хосбаяр, 2014 онд Х.Ихбаяр, Х.Их-Эрдэнэ нарын ихэр хөвгүүдээ төрүүлсэн байна.

Үргэлжлэл нь VI нүүрт

ЯРИЛЦАХ ТАНХИМ

## Ш.ЛХАМСҮРЭН: 2018 онд ипотекийн зээлээр 10 гаруй мянган өрхийг орон сууцанд оруулна



Н.ПУНЦАГБОЛД  
puntsagaa1985@gmail.com

Барилга, хот байгуулалтын дэд сайд Ш.Лхамсүрэнг "Ярилцах танхим" буланд аав урьж, ярилцлаа.

-Иргэдэд тохилог орон сууцанд орох эрэлт хэрэгцээ маш их байгаа. Гэвч нийлүүлэлт, үнэ өртөг, худалдаж авах боломжоос шалтгаалаад хэрэгцээгээ хангаж чадахгүй байна. Одоогийн байдлаар эрэлт, нийлүүлэлтийн харьцаа ямар хэмжээнд байгаа вэ?

-БХБЯ, Төрийн орон сууцны корпораци, Монголын ипотекийн корпораци хамтран орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн судалгааг шинэчлж гаргасан. 2018 оны гуравдугаар сарын байдлаар ямар байгааг эцэслэн гаргасан юм. Энэ судалгааг "Тэнхлэг зууч" компани хийсэн. Зах зээлд байгаа орон сууцнуудыг хэд хэдэн зүйлээр нарийн судлах зайлшгүй шаардлага бидэнд байсан. Судалгаагаар нийслэлд 380 орчим мянган өрх амьдарч байна. Түүний 43 хувь нь орон сууцанд амьдардаг. 217 мянган айл гэр хороололд амьдарч байгаа юм. Бидний хийсэн судалгаагаар орон сууцны нийлүүлэлт эрэлтээсээ давчихсан байна. Одоогоор 5822



айлын орон сууц борлогдоогүй байна. Том утгаар нь харвал эрэлт хангалттай бий. Гэр хороололд амьдарч байгаа 217 мянган айл өрх бүгдээрээ биш юм гэхэд олонх нь орон сууцанд орох хүсэлтэй нь тодорхой. Хамгийн гол нь орон сууц худалдан авах чадвар муу байна. 217 мянган өрхийн ердөө 16 хувь нь л орон сууцанд орох боломжтой гэсэн судалгааны үр дүн гарсан. Ингээд харьцуулаад үзвэл, 5588 айлын орон сууц эрэлтээсээ давах юм байна гэсэн судалгааны дүн гарлаа.

Үргэлжлэл нь III нүүрт

ХӨНДӨХ СЭДЭВ

## ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН

дампуурал давтагдах уу



С.БУДРАГЧАА  
budragchaas@gmail.com

Нийслэлийн одоогийн удирдлагуудын улстөржсөн, харалган шийдвэрийн улмаас тун удахгүй Нийслэлийн есөн дүүрэгт бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан 131 хоршоо зэрэг дампуурч болзошгүй нөхцөл байдал бий болоод байна. Одоогоос 16 жилийн өмнө УИХ-аас Хоршооны тухай хуульд ямар ч бодлогогүйгээр өөрчлөлт

оруулснаас үүдэн 2006 онд 26 ХЗХ шил даран дампуурч 8301 хүн хохирч байсан юм. Төрийн буруутай үйл ажиллагааны улмаас ХЗХ хоршоод хэрхэн дампуурч болдогийг, үүний улмаас хэн хохирч, хэн хожсонг та бүхэндээ өнгөрсөн түүх, өнөөгийн нөхцөл байдлынх нь хамт зэрэгцүүлэн хүргэж байна.

Үргэлжлэл нь III нүүрт

ДЭЛХИЙ

## ХУУРАМЧ

хаягийг илрүүлэхэд хялбар болжээ



Б.ДАВААХҮҮ  
Davaakhuu0128@gmail.com

Твиттер, фэйсбүүк зэрэг нийгмийн сүлжээг монголчуудын дийлэнх нь ашиглах болжээ. Зарим нь уг сүлжээнд анхлан суралцаж байхад, заримынх нь хувьд аль хэдийнэ ажил, амьдралынх нь нэг хэсэг болж хувирсан байна. Үүнийг дагаад аюулгүй байдлын асуудлууд ч сөхөгддөг. Твиттер сүлжээний нийт хаягийн ойролцоогоор дөрвөн хувь нь буюу дунджаар

20 сая орчим нь хуурамч хаяг байдаг аж. Харин фэйсбүүкийн хувьд мөн л дөрвөн хувь нь хуурамч хаяг гэх судалгаа бий. Эдгээр хуурамч хаягийг ямар зорилгоор нээснийг тодорхойлоход бэрх.

Үргэлжлэл нь III нүүрт

## УЛС ТӨР

Үргэлжлэлийг доорхи QR кодыг уншуулан худалдан авч уншина уу

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ сонин захиалахад хялбар боллоо



- ▶ **ГАР УТСААРАА** энэ QR кодыг уншуулан шилжүүлэх дансаа сонгоно уу
- ▶ **ТӨЛБӨРИЙН УТГА** дээр утасны дугаар болон и-мэйл хаягаа оруулна уу  
*/И-мэйл хаягаар таны сонин очих учраас заавал бөглөнө/*
- ▶ **ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ** товчийг дарна уу. Маргааш таны и-мэйл хаягаар манай сонин очих болно

Улирлаар захиалах бол **12000 төгрөг**  
Сараар захиалах бол **5000 төгрөг**

**УТАС: 99197866**

ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧ:  
Б.ОЮУНГЭРЭЛ



ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:  
Б.ӨНӨРТӨГТОХ 88006842

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:  
Э.ЭНХЦЭЦЭГ 90873012  
88873012

ТОЙМЧ:  
Н.ПУНЦАГБОЛД 88096454

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН АЛБА:  
Б.ПҮРЭВЖАВ 99210031

НИЙГЭМ, ГАДААД МЭДЭЭЛЛИЙН АЛБА:  
Б.ДАВААХҮҮ 98013232

КОМПЬЮТЕР, ГЭРЭЛ ЗУРГИЙН АЛБА:  
Б.ГАНЗОРИГ 99998796

МАРКЕТИНГ, БОРЛУУЛАЛТЫН  
АЛБА:

М.ДАВААДУЛАМ 99042510

Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Э.САЙНЗАЯА 99197866

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг:  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Чөлөөт хэвлэл сан  
/Хэвлэлийн хүрээлэн/,  
2 давхар, 209, 211 тоот

"Монголын мэдээ" сонины редакцид  
эхийг бэлтгэж,  
"Чөлөөт хэвлэл сан"-гийн хэвлэл  
үйлдвэрт хэвлэв.

ФЭЙСБҮҮК: [www.facebook.com/mongoliinmedeesonin/](http://www.facebook.com/mongoliinmedeesonin/)

ТВИТТЕР: [www.twitter.com/MongoliinMedee](http://www.twitter.com/MongoliinMedee)